



ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ХҮҮХДЭД ЭХ ХЭЛ СОЁЛЫН ХИЧЭЭЛ ЯВУУЛЖ БУЙ БАГШ НАРТ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэслэл:

Дэлхий нийтэд онцгой нөхцөл байдал (Цар тахал) тулгарч буй энэ цаг үед сургалтын цахим хэлбэрийг сонгон ашиглах боллоо. Үүнтэй холбоотой хилийн чанад дахь монгол хүүхдийн эх хэл соёлын хичээлийг зохион байгуулж буй багш нарт мэргэжил, арга зүйд дэмжлэг үзүүлэх шаардлага бий болоод байна.

Зорилго:

Хилийн чанад дахь монгол хүүхдэд эх хэл, соёлын хичээл явуулж буй багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

Хамрах хүрээ:

Хилийн чанад дахь монгол хүүхдэд эх хэл, соёлын хичээлийг зааж буй багш нар

Хэрэгжүүлэгчид:

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт

Үргэлжлэх хугацаа:

2020.03.27 - 2020.06.19

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах, зохион байгуулах эзэн	Тэмдэглэл
1	Багш нарын хэрэгцээг тодорхойлох цахим уулзалт хийх	2020.03.27	Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа	ХЧМЗ, БМДИ, БХ, 23 сургууль гадаад дахь багш нарын төлөөлөл оролцоно.
2	Ажлын хэсэг төлөвлөгөөний талаар уулзалт зохион байгуулах, ажлын хэсэг байгуулах, төлөвлөгөө гаргах	2020.03.30	Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа Д.Отгонтуяа	Ажлын хэсэг байгуулах, багш нарын хэрэгцээт агуулгын сэдвийн талаар судалгаа авах

3	Туршилт хичээл зохион байгуулах		2020.04.09 эхлэх	Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа Д.Отгонтуяа	Zoom app цахим хичээлд хэрэглэж турших
4	ЗАЙН СУРГАЛТ- Үндсэн сургалтын агуулгаас судлах боломж олгох		2020.04.09 эхлэх	Б.Мөнхдэлгэр Б.Цогбадрах Д.Энх-Амгалан	Багш нарийн gmail хаягийг нэгтгэн moodle sistem дээр цонх үүсгэх
5	ЦАХИМ СУРГАЛТ-ын төлөвлөгөө	Цахим сургалтын төлөвлөгөөг боловсруулах	2020.04.13	У.Туяа А.Туяа Ж.Гэрэлмаа Б.Мөнхдэлгэр Д.Отгонтуяа	Боловсруулалт хийх, хугацааг товлох
		Цахим сургалтыг зохион байгуулах	2020.04.17- 2020.06.19	Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа Д.Отгонтуяа	Бэлтгэл хангах, zoom link бэлтгэх, ажлын хэсгийн нэгдсэн чат үүсгэх
6	Хэлэлцүүлэг	Монгол хүний үнэт зүйл, уламжлалт ёс заншил	2020.05.05	Б.Мөнхдэлгэр Д.Отгонтуяа	БМДИ - ХЧМЗ хамтран бэлтгэх
		Хүүхдийн сэтгэл зүйг судлах арга, аргачлал	2020.05.19	Золзаяа Б.Мөнхдэлгэр	Сэтгэл судлалын хүрээлэнтэй хамтрах
		Хүүхэд, эцэг эх, багшийн нэгдмэл үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх	2020.06.09	Д. Нямсүрэн Б. Мөнхдэлгэр	Dash гэр бүл судлалын төвтэй хамтрах
7	Нэгдсэн хэлэлцүүлэг		2020.06.19	Д.Отгонтуяа Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа	Сургалтын үр дүн, сэтгэл ханамжийн судалгааг асуулга, ярилцлагын аргаар авах, мэдээллийг боловсруулах, нэгтгэн дүгнэх
8	Бүтээгдэхүүн, үр дүн		2020.06.26	Д.Отгонтуяа Б.Мөнхдэлгэр Ж.Гэрэлмаа	1. Цахим сан бий болгох эхлэл тавигдах 2. Нэгдсэн тайлан гарах



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН



ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ
МОНГОЛЧУУДЫН ЗӨВЛӨЛ



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ

ГАДААД ДАХЬ МОНГОЛ ХҮҮХДЭД ЭХ ХЭЛ, СОЁЛЫН ХИЧЭЭЛ ЯВУУЛЖ БУЙ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ЦАХИМ* СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хугацаа: 2020 оны 4 сарын 17-ноос 6 сарын 19

№	Сэдэв	Агуулгын хүрээ	Хүрэх үр дүн	Хугацаа** (Монголын цагаар)	Бэлтгэх зүйл	Үнэлгээ	Удирдах багш***
1	Нэгж ба ээлжит хичээлийг хэрхэн төлөвлөх вэ?	1. Багшийн төлөвлөгөөний төрөл, хөтөлбөрт тавигдах шаардлага. 2. Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт	Багшийн ээлжит хичээлийн төлөвлөлтийн арга зүй сайжирсан байна.	4 сарын 17 15.00-16.00 (60 минут)	Багш нар өөрийн ээлжит хичээлийн төлөвлөлтийн жишээ авчрах	1. Багш бүрээр нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар хийлгэн цахим хэлбэрээр үнэлнэ. 2. Сорил - мэдлэг үнэлэх	Б.Цасанчимэг Ж.Гэрэлмаа
2	Даалгавар боловсруулах арга зүй 1: Явцын болон үр дүнгийн үнэлгээний даалгавар	Үнэлгээ болон үнэлгээний даалгавар гэж юу вэ? Үнэлгээний төрлүүд ба даалгаврын төрлүүд	Үнэлгээний даалгавар боловсруулж сурах	4 сарын 24 15.00-16.00 (60 минут)	Багш нар өөрийн даалгаврын сангаас 10 хүртэл даалгавар сонгож дараах байдлаар ангилахыг оролдсон байна.	Даалгавар боловсруулсныг цахим хэлбэрээр авч дүгнэнэ	М.Оюунчимэг У.Туяа
3	Даалгавар боловсруулах арга зүй 2: Даалгаврыг зорилго болон түвшингээр хялбарчлан боловсруулах нь	Хялбарчлал гэж юу вэ? Монгол хэлийг хоёрдогч хэлний хичээл болгон заах арга зүй. Даалгаврыг хялбарчлал	Багш нар төрөл бүрийн даалгаврын сангаас суралцагчийн онцлогт тохирсон даалгаврыг хялбаршуулан боловсруулж, үр дүнтэй ашиглаж сурсан байна	5 сарын 1 15.00-16.00 (60 минут)	1.Зорилгоор нь ангилах 2.Түвшингээр нь ангилах	Янз бүрийн сангуудаас даалгавар ашиглах	Ж.Гэрэлмаа Ц.Баясгалан
4	Даалгавар боловсруулах арга зүй 3: Үнэлгээний даалгаврыг цахим хэлбэрээр боловсруулж, ашиглах боломж	Онолын, бие даалтын, сорилын сангуудтай ажиллах	Онлайн программ дээр ажиллах чадвараа хөгжүүлэх	5 сарын 8 15.00-16.00 (60 минут)	1. 30 төрлийн даалгавар боловсруулж цахим (word, audio) хэлбэрээр авч ирэх 2. Багшаас урьдчилж заавар өгсөн байна	Сорилын программын командуудыг ашиглан боловсруулсан даалгавраа оруулж чадаж байгаа эсэхээр үнэлнэ.	А.Мөнхмагнай Ж.Гэрэлмаа

5	Зорилтот хэлийг хурдан эзэмших арга аргачлал, түргэн уншлага	Хэл эзэмших дэс дараа, сэтгэл зүйтэй холбогдох нь. Сэтгэлээ тогтоох ёс	Зорилтот хэлийг сургахтай холбогдсон бэрхшээлүүдийн талаар үнэн зөв ойлголттой болж улмаар түүнийг гэтлэн давах аргуудыг зөв тодорхойлох	5 сарын 15 15.00-16.00 (60 минут)	Монгол хэлийг хурдан эзэмшүүлэх өөрийн арга туршлагаасаа хуваалцахад бэлдэж ирнэ.	Ярилцлагаар үнэлнэ.	Д.Болдбаатар Ж.Гэрэлмаа
6	Сурагчийн унших чадварыг дэмжих арга, аргачлал	Үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгож унших чадварыг хөгжүүлэх	Багш, дасгал даалгавруудыг ашиглан, сурагчдын үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгож унших чадварыг хөгжүүлэх, уншсанаа ойлгосон эсэхийг үнэлэх арга техникийг эзэмших	5 сарын 22 15.00-16.00 (60 минут)	Бичлэгийг үзэж ирнэ. https://www.youtube.com/watch?v=Inwa9A1CBc&t=72s	Уншсанаа ойлгосныг илрүүлэх талаар асуулгыг Google form программ ашиглан авч үнэлнэ.	Д.Цогзолмаа Ж.Гэрэлмаа
7	Идэвхтэй сургалтын аргууд, цахим хичээлд ашиглах арга зам	Идэвхтэй сургалтын аргуудын талаар мэдлэг ойлголтоо дээшлүүлэх, цахим сургалтад ашиглах боломжуудыг мэдэх	Идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэх чадварт ахиц гарна Цахим хичээлээ төлөвлөхдөө ИСА-аас оновчтой сонгон, ашигладаг босон байна.	5 сарын 29 15.00-16.00 (60 минут)	1. Илгээсэн материалуудыг уншиж ойлгосон байна. Ойлгомжгүй зүйлсийг асуухад бэлдэж ирнэ. 2. ИСА-уудаас аль нэгийг сонгон цахим хичээлдээ туршиж, туршлагаа бусадтай хуваалцахаар бэлдэж ирэх	1. Сорил ажиллах. 2. Хичээлийн бэлтгэлд үнэлгээ өгөх	Д.Отгонтуяа Д.Ганчимэг

8	Цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга	Аудио, видео, зурган хэрэглэгдэхүүнийг цахим хэлбэрээр ашиглах нь	Аудио болон видео, зурган материалуудыг хичээл заах программдаа оруулах, оновчтой ашиглах	6 сарын 5 15.00-16.00 (60 минут)	1. Өөрийн сургалтад ашиглах зураг бичлэгийн санг бүрдүүлэх /сан бүрдүүлэхэд хэрэглэгч хүснэгт бүхий цахим сангийн загвар багш нарт өгнө/ 2. Өөрийн дуу хоолойг оруулах микрофон болон гар утасны дуу хураагуурыг ашиглах чадвар эзэмшсэн байх /урьдчилан богино хэмжээний видео хичээл бэлтгэн хүргэх болно/	Сургалтаас эзэмшсэн агуулгуудын бүрдэл бүхий бүтээлийн үр дүнгээр 1-2 ppt хичээл боловсруулах өөрийн өмнөх хичээлийг сайжруулсан байж болно /технологийн болон ур чадварын түвшинг харгалзан үнэлэх/ .	Э.Энхбаяр Б.Мөнхдэлгэр
9	Зайн сургалтад хэрэглэх боломжит технологиуд	Зайны сургалтын аргууд, тэдгээрийг дэмжих технологийн боломжууд	Зайн сургалт зохион байгуулахад тулгарч буй бэрхшээлийг даван туулах аргуудыг мэдэх, турших	6 сарын 12 15.00-16.00 (60 минут)	Зайн сургалт зохион байгуулах явцад тулгардаг бэрхшээлүүдийн талаар асуулт бэлдэж 6 сарын 5-ны өдрөөс өмнө багшид ирүүлсэн байх.	Эзэмшсэн мэдлэгийг өөрийн үнэлгээгээр үнэлнэ.	А.Мөнхмагнай Б.Намсрайдорж
10	Гадаадад амьдарч буй бага насны монгол хүүхдийн эх хэл хөгжүүлэх арга зам	Гадаад дахь монгол хүүхдийн эх хэлний хөгжлийн онцлог, хүүхдэд монгол хэлийг эзэмшүүлэх аргачлал	Хүүхдийн хэл ярианы хөгжлийн онцлогийг танин мэдэж түүнд нь тохирсон агуулга, арга, хэлбэрийг сонгож үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай болно	6 сарын 19 15.00-16.00 (60 минут)	1. Таны амьдарч буй оронд бага насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлдэг цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг судалж, туршлагыг танилцуулахад бэлдэх 2. 3 хүртэлх ба 3-5 насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх аргачлал боловсруулж ирэх	1. Багш нар өөрсдийн мэдлэг чадвараа ашиглаж цахим хичээлээ боловсруулж буйг үнэлнэ. 2. Багшийн хичээлээр ойлгосон агуулгыг ойлгосон эсэхийг сорилоор үнэлнэ. (Quiz-ээр)	Х.Монголхатан С.Пүрэвсайхан

*Сургалтыг ZOOM зайны сургалтын программыг ашиглан явуулна.

**Нэг сэдвийн хугацааг (60 минут) ойролцоогоор тооцсон бөгөөд шаардлагатай нөхцөлд тухайн үед зохицуулна.

***Цахим сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ХЧМЗ-ийн Боловсролын хорооны багш нараас санал зөвлөмж авна.